

ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ОСЛЫН ҮЕД АВРАХ БАГАЖ ХЭРЭГСЭЛ АШИГЛАХ АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА USING RESCUE UTILITIES SAFELY FOR A VEHICLE ACCIDENT



У.Ганхөлөг. ХСИС-ийн Онцгой байдлын сургуулийн Гамшгаас хамгаалах албаны тэнхимийн эрхлэгч, онцгой байдлын хошууч
Gankhulug.U. Head of Disaster Protection Service Faculty, Emergency Management Institute, Law Enforcement University, Major

Abstract: Automobiles and vehicles are increasing while the cities are grown and crowded. Whenever the country seems developing, its disadvantage is to increase car accident. It is required to improve our lifeguards and rescuers' knowledge, skills and develop our rescue utilities because of raising car accident calls at Emergency Management Service. It is important to organize our service skillfully and immediately by using the rescue utilities by "Holmatro" from Holland for Emergency Management Service today. Any dangerous may be serious harmful. Personal safety depends on the level of training and practice, using bodyguard utilities skillfully, and using official instruments and devices safely. Therefore, lifeguards or rescuers should study the instructions of rescue utilities carefully and understand them well. It is a vital to follow the instructions of authorities and special organizations during the disaster.

Дэлхий нийтэд байгалийн болон техникийн холбогдолтой гамшиг, аюулт үзэгдлийн тоо, давтамж жилээс жилд нэмэгдэх хандлагатай болж байна.

Хот суурин газрууд нэмэгдэж хүн амын төвлөрөл нягтаршихын хэрээр авто машин, тээврийн хэрэгслийн хэрэглээ ихсэж байгаа нь улс орны нийгэм, эдийн засгийн хөгжлийг сайжирч байгаа мэтээр харуулж байгаа хэдий ч сайны хажуугаар сөрөг зүйл байнга дагаж явдгийн илрэл нь тээврийн хэрэгслийн ослын тоо ихсэж байгаагаар харагдаж байна.

Зам тээврийн ослыг шууд утгаар нь гамшиг гэж ойлгож болохгүй ч жилийн статистик нэгдсэн дүнг аваад үзвэл зам тээврийн ослын улмаас нас барагсад, нэрвэгдэгсдийн тоо нь үлэмж их байх бөгөөд түүнээс урьдчилан сэргийлэх, аврах ажиллагааг зохион байгуулах асуудал чухлаар тавигдаж байна.

Онцгой байдлын албанд зам тээврийн ослын дуудлага байнга ирдэг нь аврах багаж хэрэгсэл, аврагчдын мэдлэг, чадварыг дээшлүүлэх шаардлагыг зүй ёсоор тавьж байна. Сүүлийн үед Онцгой байдлын албанд Голландын "Холматро" фирмийн аврах багаж хэрэгслийг өргөнөөр ашиглах болсон нь аврах ажиллагааг шуурхай, чанартай зохион байгуулахад чухал үүрэг гүйцэтгэж байгаа юм.

Гамшгийн төрөл бүр өөрийн гэсэн онцлогтой, давтагдашгүй гэдгийг санах хэрэгтэй. Аврах багаж хэрэгсэл болон арга зүйг автомашины төрөл, ослын газарт байгаа автомашинуудын тоо, байрлал, нэрвэгдэгсдийн тоо, тэдний биеийн байдал болон бусад хүчин зүйлүүдээс хамааран сонгодог.

Тухайн гамшгийн үед ямар аврах багаж хэрэгсэл, арга зүйг сонгон хэрэглэх нь аврагч болон тусламж үзүүлж буй бусад хүмүүсийн хувийн хариуцлагын асуудал байдаг.

Ямар ч гамшгийн нөхцөл байдал нь асар аюултай байж болно. Хувийн аюулгүй байдал нь сургалт, бэлтгэлжилтийн түвшин, бие хамгаалах хэрэгслийн чадварлаг ашиглалт, түүнчлэн албанд ашиглагдаж байгаа аврах багаж хэрэгслийг зөв хэрэглэх чадвар зэргээс хамаардаг. Тиймээс аврагчид аврах багаж хэрэгсэлтэй ажиллах зааврыг анхааралтай судлан, ойлгож авах хэрэгтэй. Гамшгийн үед эрх бүхий байгууллага, түүний албан ёсны төлөөлөгчдийн гаргасан зааврыг байнга удирдлага болгох нь чухал юм.

Ямар ч төрлийн аврах ажиллагаа явуулахад юуны түрүүнд аврагчид өөрсдийн аюулгүй байдлыг сайтар хангасан байх ёстой бөгөөд нэг бүрийн хамгаалах

хэрэгслийг зохих журмын дагуу хэрэглэж, аюулгүй ажиллагааны техник, арга зүйг ягштал баримтлахыг шаарддаг.

Бие хамгаалах иж бүрдэл нь үйлдвэр, байгууллагын ажлын тогтсон онцлогтой уялдан бүтээгдсэн байдаг. Аврагч бүр хамгаалалтын хувцас өмсөж, аюулгүй байдлын бүхий л шаардлагыг ханган биелүүлэх шаардлагатай. Эдгээр шаардлагууд нь холбогдох удирдамжид нийцсэн байна. Үүнд:

- Дуулга нь бие хамгаалах хэрэгслийн салшгүй нэг хэсэг бөгөөд түүнийг бүхий л ажиллагааны явцад зайлшгүй өмссөн байх шаардлагатай.
- Нүд хамгаалах хэрэгсэл (хамгаалалтын нүдний шил) нь нүүрний бүтэн хамгаалалт (хамгаалалтын хаалт)-ын хамт аврах ажиллагааны явцад зайлшгүй ашиглагдана. Хамгаалалтын хаалт нь нүдийг бүрэн гүйцэд хамгаалж чаддаггүй.
- Бүхий л ажиллагааны явцад хамгаалалтын бээлийг өмсөх шаардлагатай.
- Хамгаалалтын хувцас нь биеийн бүхий л хэсгийг бүрхэж байх ёстой бөгөөд биеийг хурц үзүүр, өнцөгтэй зүйлсээс хамгаалдаг. Мөн хамгаалах хувцас нь зарим тохиолдолд галын дөл, хорт бодисоос хамгаалах үүрэг гүйцэтгэдэг.
- Хамгаалалтын гутал нь хальтрахаас найдвартай хамгаална.
- Шил, металл бусад материалыг зүсэх үед өчүүхэн жижиг хэлтэрхийнүүд үүсч амьсгалын эрхтнийг гэмтээж болзошгүй. Иймээс энэ төрлийн материалуудтай ажиллах үедээ хошуувч (респиратор) ашиглах нь зүйтэй.

Аливаа тоног төхөөрөмжийг ашиглаж эхлэхийн өмнө ашиглах зааврыг зайлшгүй уншиж, ажиллагааны зарчмыг ойлгож авах нь чухал. Тэрчлэн дараах үндсэн дүрмүүдийг санаж явах хэрэгтэй. Үүнд:

- Багажийг хэрэглэх үедээ эдгээр багажууд болон тээврийн хэрэгслүүдийн хооронд зогсохыг хориглоно;
- Хоолойнууд нь ашиглах явцад амархан гэмтэж (хатуу материал, өндөр температур, химийн бодисын нөлөөгөөр урагдах, хугарах, элэгдэх) болох талтай тул маш анхааралтай байхыг шаарддаг. Ямар нэгэн байдлаар гэмтсэн хоолойг хэрхэвч ашиглаж болохгүй бөгөөд нэн даруй солих шаардлагатай;
- Тоног төхөөрөмж, шахуургыг зөөвөрлөхдөө хоолойноос барихыг хориглоно;
- Шингэний хоолойнууд дээр гишгэхийг хориглоно;
- Тайрах үед тээврийн хэрэгслийн жижиг хэсгүүд ойх, үсрэх аюултай учраас ажиллагааг байнгын хяналтын доор гүйцэтгэх ёстой;
- Тухайн ажилд ашиглагдаагүй байгаа багаж хэрэгслүүдийг тусгайлан зассан талбайд, ажлын горимын "сул" байрлалд тохируулан байрлуулна;
- Ашиглагдаж байгаа бүхий л багаж хэрэгслүүдийг зөөвөрлөхдөө зориулалтын бариулыг ашиглах хэрэгтэй.



Аврах багаж хэрэгсэл нь тэлэгч, тасдагч, өргүүр (домкрат) гэсэн ерөнхий төрлүүдтэй байх бөгөөд тэдгээртэй ажиллах үеийн ерөнхий зарчмыг доор сийрүүлэв.

А. Тэлэгч

Тэлэгч нь маш хүчирхэг багаж бөгөөд зөв ашиглавал нүүлгэн шилжүүлэх ажиллагааны үед гайхалтай ашигтай багаж болох нь харагдана. Хэрэв буруу, эсвэл болгоомжгүй ашигласан тохиолдолд тодорхой аюулыг дагуулдаг.

Тэлэгчийг ашиглахдаа доор дурьдсан байрлалуудыг зайлшгүй санаж байх хэрэгтэй. Хамгийн гол нь төхөөрөмжийг тогтвортой тулгууртай талбайд зөв байрлуулах нь чухал юм. Тэлэгч багаж тэлж эхлэх агшингаас эхлээд тэр нь өөрийн бүхий л жингээрээ үйлчилж эхэлдэг бөгөөд тухайн агшингаас түүнийг удирдлагын бариулын тусламжтайгаар барьж, удирдахад л хангалттай.

Зайлшгүй санаж байх ёстой зүйлс:

- Тэлэгчийн үзүүрүүдийн гадаргууг аль болох бүтнээр нь оруулахыг хичээх;
- Хэрэв тэлэх явцад үзүүрүүд гулгаж эхэлвэл ажиллагааг нэн даруй зогсоож төхөөрөмжийг анхны байрлалд оруулна;
- Багажийг жижиг хэсэг, хэлтэрхийнүүд тээврийн хэрэгслээс гадагш шахагдан гарч байхаар байрлуулах хэрэгтэй;
- Ажиллагааны явцад багажны өөрийн шилжилт хөдөлгөөнийг та зогсоож чадахгүй. Хэрэв таны хувцас эсвэл та өөрөө тээврийн хэрэгсэл, багаж хоёрын хооронд хавчуулагдвал багажны ажиллагааг зогсоож, түүнийг анхны байрлалд оруулаарай;
- Ямар ч тохиолдолд тэлэгчийн эрүү болон үзүүр хэсгээс гараараа бүү барь;
- Тэлэгчтэй ажиллаж дууссаны дараа түүнийг заавал аюулгүй байрлалд тохируулна.



Тэлэгчийн зөв байрлал.



Тэлэгчийг бариулаас нь зөв барих байдал.

В. Тасдагч

Тасдагч нь аврах ажиллагааны хамгийн чухал хэрэгсэл болдог. Энэ нь тээврийн хэрэгслийн загвар, хийцийн тасралтгүй сайжруулалт болон тасдах технологитой холбоотой байдаг. Болгоомжгүй хэрэглээнээс үүдэн эдгээр багажийн тасдах болон эвдлэх их хүч нь томоохон аюулыг дагуулдаг.



Үзүүрүүд нь бүхий л гадаргуугаараа хүрэлцэнэ.



90 градусийн өнцгөөр тасдагч.



Таслах үеийн зөв байрлал.

Зайлшгүй санаж байх ёстой зүйлс:

- Тасдагчийг тасдах зүйлийн гадаргуу дээр 90 градусын өнцөг үүсгэж байхаар байрлуулна;
- Тасдагчийн ирийг тасдах зүйлд аль болох гүн суулгаж өгөх шаардлагатай. Тасдагчийн ирний төгсгөл хэсгээр тасдахаас аль болох зайлсхий;
- Хэрэв тасдагч хэт хүчтэй эргэх, огцом эргэлдэх, эсвэл та ир нугаларч, тахийхыг анзаарвал нэн даруй ажиллагааг зогсоож, тасдагчийг дахин байрлуулна;
- Тасдах ажиллагааг аюулгүйн дэрийг шахаж гаргах болон бусад нуугдмал, аюул учруулж болзошгүй хэсэгт гүйцэтгэхгүй байх;
- Аливаа тасдагчийн ирнээс нь гараараа хэзээ ч бүү барь;
- Ажлын явцад багажны өөрийн шилжилт хөдөлгөөнийг та урьдчилан зогсоож чадахгүй. Хэрэв багаж эсвэл таны хувцас тээврийн хэрэгслийн завсар хавчуулагдвал ажлыг нэн даруй зогсоож, шинээр эхлэх шаардлагатай.



Материал руу ирийг гүн оруулах хэрэгтэй.



Тасдагчийн ирний төгсгөл хэсгээр тасдахаас зайлсхий.

С. Өргүүр(домкрат)

Өргүүрүүд нь шингэн шахуургат хэрэгслийн иж бүрдлийн чухал хэсэг юм. Эдгээр нь тасдагч, тэлэгчийг бодвол тэр бүр байнга хэрэглэгдээд байдаггүй ч тээврийн хэрэгслийн урд хэсэг нэрвэгдэгчийг гаргах ажиллагаанд саад болж байгаа үед чухал үүрэг гүйцэтгэдэг. Өргүүрүүд нь өндөр ачааллыг авч байдаг болохоор тулгуураа алдсанаас тулах цэгээс гулгах болон тэдгээрийн хавчилт нь үлэмж хэмжээний аюулыг учруулж болзошгүй.

Зайлшгүй санаж байх ёстой зүйлс:

- Шингэнт өргүүр нь удирдлагын бариул нь хялбар хүрч болохуйцаар, гэхдээ нэрвэгдэгчийг гаргах ажиллагаанд саад учруулахгүйгээр байрласан байх;
- Хэрэв өргөх, хөдөлгөх ажиллагааг зогсоосон бол ажиллагааг үргэлжлүүлэхийн өмнө удирдлагын бариулын чиглэлд онцгой анхаарал хандуулах хэрэгтэй. Хэтэрхий хурдан буулгах, шингэнт өргүүрийн даралтыг огцом унагах зэргийг хориглоно. Өргүүрийн 2 тулах цэгт онцгой анхаарал хандуулах ёстой.
- Тулгуурыг найдвартай тогтоохын тулд өргүүрийн нэмэлт тулгуурыг зайлшгүй ашигладаг;
- Даралт өгөхийн өмнө доод тулах цэгийн доор объектын найдвартай тогтвортой байдлыг хангана.



Удирдлагын бариул нь хялбар хүрч болохуйц байна.



Сайн тулах цэг.



Өргүүрийн тулгуурыг ашиглах нь.



Өргүүртэй ажиллахаас өмнө каркасыг тасдах ажлыг гүйцэтгэнэ.

(Үргэлжлэл бий)